



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

### Аудитын код: БУА-2026/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2025 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Батцогт  
Утас: 70342716 Цахим хаяг: [battsogtd@audit.gov.mn](mailto:battsogtd@audit.gov.mn)

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 70342716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит  
ХХК-ийн

Гүйцэтгэх захирал С.Оргил  
Утас:99197346

Цахим хаяг: [Info@shinjlenmagadlakhui-audit.mn](mailto:Info@shinjlenmagadlakhui-audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>4-8</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	<b>9-91</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>111-13</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БГ	Боловсролын газар
СХДАГ	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <b>БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> Анхдагчдын өргөн чөлөө 1-120, Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг, 63082, Утас/Факс: 7034-2580 Цахим шуудан: bulgan@audit.gov.mn	<b>ОРХОН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д.УРТНАСАН ТАНАА</b>
2026.02.24 № 288 тантай _____ ны № _____ т	
<b>Хязгаарлалттай дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Аудитаар Орхон сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар эмчилгээ үйлчилгээний нэхэмжлэлийг шалгаж 23,632.10.4 мянган төгрөгийг хассаныг хянаж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч хариуцлага тооцон ажиллаагүй, ХХОАТ-ын нийгмийн даатгалын шимтгэл нь 1,347.27 мянган төгрөг, 1 дүгээр сараас 12 дугаар саруудын цалинг тооцоолохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн код алдаатай татагдснаас 2,323.9 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн зэрэг 27,303.34 мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил илэрсэн.</p> <p>Иймд тус эмнэлгийн санхүүгийн тайлагнал нь УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p>	
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b>	
<p>Орхон сумын Эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 50 сая төгрөгийн үнийн дүнтэй сэргээн засахын тоног төхөөрөмж худалдан авах</p>	
<b>6326050410</b>	

гэрээг "Хос анар" ХХК тай байгуулж, хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Орхон сумын Эрүүл мэндийн төвийн дарга Булган аймгийн Эрүүл мэндийн төвийн даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 9-н хөтөлбөр 9 арга хэмжээний хүрээнд боловсруулагдан батлагдаж, гүйцэтгэлээр 93.0 хувиар үнэлэгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д. БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>208,747,565.93</u></b>	<b><u>109,957,603.87</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	69,635,860.95	39,072,876.63
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	69,635,860.95	39,072,876.63
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	69,635,860.95	39,072,876.63
31211	Төрийн сангийн харилцах	69,635,860.95	39,072,876.63
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	93,661,836.74	24,801,698.35
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	93,661,836.74	24,801,698.35
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	45,449,868.24	46,083,028.89
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	39,468,988.44	20,515,012.36
35110	Тусгай зориулалттай материал	32,000.00	674,600.00
35130	Эм боох материал	39,436,988.44	19,840,412.36
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,980,879.80	25,568,016.53
35410	Бичиг хэргийн материал	698,500.00	-
35420	Аж ахуйн материал	410,500.00	9,491,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	40,000.00	335,000.00
35440	Түлш, шатах тослох материал	670,700.00	3,800,000.00
35450	Барилгын засварын материал	45,800.00	54,500.00
35460	Хүнсний материал	1,716,245.30	2,511,132.03
35470	Бусад хангамжийн материал	2,399,134.50	9,376,134.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>270,888,518.78</u></b>	<b><u>2,569,140,622.01</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	270,888,518.78	2,569,140,622.01
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	266,578,518.78	2,565,117,955.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	118,269,512.02	2,434,569,512.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,414,707.32	- 75,351,016.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,998,537.00	78,998,537.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-43,373,888.90	- 50,393,262.98
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	217,736,008.62	293,236,958.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 87,334,114.77	- 132,022,857.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,768,528.96	29,768,528.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 9,756,771.83	- 14,373,859.75
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	685,415.00	685,415.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,310,000.00	4,022,666.72
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 300,000.00	- 300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,310,000.00	4,310,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	- 287,333.28
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>479,636,084.71</u></b>	<b><u>2,679,098,225.88</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>479,636,084.71</u></b>	<b><u>2,679,098,225.88</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>479,636,084.71</u></b>	<b><u>2,679,098,225.88</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	101,341,290.1	101,341,290.1
51101	Өмч: - төрийн	101,341,290.1	101,341,290.1
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	306,253,895.12	2,505,716,036.29
51210	Өмнөх үеийн үр дүн	306,253,895.12	306,253,895.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,199,462,141.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	72,040,899.54	72,040,899.54
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>479,636,084.71</u></b>	<b><u>2,679,098,225.88</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>943,743,834.13</b>	<b>926,352,272.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>61,443,400.00</b>	<b>16,776,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	61,443,400.00	16,776,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,443,400.00	16,776,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,443,400.00	16,566,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>882,300,434.13</b>	<b>909,576,272.56</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	60,035,200.00	65,728,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,035,200.00	65,728,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	822,265,234.13	843,847,872.56
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	822,265,234.13	843,847,872.56
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>841,057,277.59</b>	<b>1,066,197,245.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>841,057,277.59</b>	<b>1,066,197,245.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	838,697,427.67	1,039,893,390.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	556,590,701.50	668,568,610.52
210101	Үндсэн цалин	320,805,842.23	382,598,959.01
210102	Нэмэгдэл	186,729,717.08	219,915,855.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,675,000.00	23,488,000.00
210104	Урамшуулал	35,380,142.19	42,565,796.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,245,826.43	81,217,212.92
210201	Тэтгэврийн даатгал	49,025,742.25	54,044,700.21
210202	Тэтгэмжийн даатгал	5,830,434.36	6,879,044.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,784,867.31	3,494,373.67
210204	Ажилгүйдлийн даатгал	2,720,956.55	3,360,576.56
210205	Эрүүл мэндийн даатгал	10,883,825.96	13,438,517.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	55,426,210.08	57,757,630.26
210301	Гэрэл, цахилгаан	4,481,726.56	5,227,920.50
210302	Түлш, халаалт	50,894,483.52	51,491,573.76
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	1,038,136.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,671,678.23	24,450,200.00
210401	Бичиг хэрэг	2,836,200.00	3,529,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,066,119.96	7,566,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,042,741.40	1,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,741,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,698,700.00	1,585,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,286,116.87	10,118,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	86,296,666.75	93,201,695.12
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,021,406.06	82,560,881.85
210502	Хоол, хүнс	14,038,760.69	10,640,813.27
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,236,500.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,157,511.43	1,761,600.00

**Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн  
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,451,441.43	499,900.00
210604	Урсгал засвар	1,706,070.00	1,261,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,542,100.00</b>	<b>3,508,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,542,100.00	3,508,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,907,564.00</b>	<b>4,448,624.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,710,108.00	3,758,624.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	19,206.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,859,169.25</b>	<b>104,979,217.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,628,580.00	11,430,370.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	419,860.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,810,729.25	93,548,846.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,359,849.92</b>	<b>26,303,855.74</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>2,359,849.92</b>	<b>-</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,359,849.92	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>19,566,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,566,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>6,737,855.74</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,737,855.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>102,686,556.54</u></b>	<b><u>- 139,844,973.24</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>102,686,556.54</u></b>	<b><u>- 139,844,973.24</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>861,853,823.39</u></b>	<b><u>995,212,410.95</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>61,443,400.00</b>	<b>16,776,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>61,443,400.00</b>	<b>16,776,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>61,443,400.00</b>	<b>16,776,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,443,400.00	16,566,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>800,410,423.39</b>	<b>978,436,410.95</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>60,035,200.00</b>	<b>65,728,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,035,200.00	65,728,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>740,375,223.39</b>	<b>912,708,010.95</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	740,375,223.39	912,708,010.95
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>793,356,566.26</u></b>	<b><u>1,021,699,495.27</u></b>

**Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн  
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>793,356,566.26</b>	<b>1,021,699,495.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>790,996,716.34</b>	<b>995,395,639.53</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	560,914,823.43	668,243,703.48
210101	Үндсэн цалин	325,129,964.16	391,551,391.96
210102	Нэмэгдэл	186,729,717.08	219,915,855.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,675,000.00	23,488,000.00
210104	Урамшуулал	35,380,142.19	33,288,456.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,245,826.43	85,640,283.39
210201	Тэтгэврийн даатгал	49,025,742.25	58,467,770.68
210202	Тэтгэмжийн даатгал	5,830,434.36	6,879,044.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,784,867.31	3,494,373.67
210204	Ажилгүйдлийн даатгал	2,720,956.55	3,360,576.56
210205	Эрүүл мэндийн даатгал	10,883,825.96	13,438,517.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	55,696,738.21	56,719,494.26
210301	Гэрэл, цахилгаан	4,039,114.69	5,227,920.50
210302	Түлш, халаалт	51,607,623.52	51,491,573.76
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,234,442.40	32,193,350.00
210401	Бичиг хэрэг	4,174,480.00	2,533,600.00
210402	Тээвэр, шатахуун	15,737,721.00	10,695,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,042,741.40	1,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	3,153,900.00	1,383,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,125,600.00	15,931,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	66,514,210.00	67,745,298.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,114,200.00	53,322,048.40
210502	Хоол, хүнс	15,395,010.00	11,030,250.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,005,000.00	3,393,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,812,111.87	64,711,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	61,064,700.00
210602	Тавилга	-	300,000.00
210604	Урсгал засвар	2,812,111.87	3,346,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,110,100.00	3,508,600.00
210702	Дотоод албан томилолт	3,110,100.00	3,508,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,907,564.00	6,648,022.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,710,108.00	5,243,216.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	283,806.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	19,206.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	431,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,560,900.00	9,985,638.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,560,900.00	9,985,638.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,359,849.92</b>	<b>26,303,855.74</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	2,359,849.92	-

**Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн  
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,359,849.92	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	19,566,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,566,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	6,737,855.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,737,855.74
213404	Хөрөнгийн		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>68,497,257.13</u></b>	<b><u>- 26,487,084.32</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>4,920,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>4,920,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	4,920,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	3,900,000.00
223001	Бусад хөрөнгө	-	1,020,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	≡	<b><u>- 4,920,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	68,497,257.13	- 31,407,084.32
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		69,635,860.95
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	69,635,860.95	39,072,876.63

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	2,199,462,141.17	2,199,462,141.17
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>2,199,462,141.17</b>	2,199,462,141.17

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

### **3. АУДИТЫН ТАЙЛАН**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Булган сумын 1-р сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК”-ийн аудитын баг С.Дарьсүрэн, Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардал 841,057.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,615.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар буюу 9,461.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно.

#### **3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 107 мэдээллийг бүрэн оруулж, 64 мэдээлэлийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ.

Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Албан шаардлага/

#### **Шийдвэрлэсэн нь:**

Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөн баталж, дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээх, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг цахим системд мэдээлж байх.

### 3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд хийж гүйцэтгэсэн.

#### 3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

- *Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтөлж. стометрийн заалтыг дахин нягтлан шалган, шатахууны зарцуулалтын тооцоог дахин нягталж гаргасан. Анхан шатны баримтыг үнэн зөв үйлдэж, нягтлан бодогчоос зөвшөөрөл авч, байгууллагын даргаар баталгаажуулж ажиллахыг*

тухайн ажилтанд үүрэг болгон хэрвээ зөрчсөн тохиолдолд тухайн шатахуун авсан ажилтан хариуцахаар

- Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдлийг нэг аравны хоёр дахин нэмэгдүүлж 2025 оны 7 сарын 1-ний өдрөөс олгож эхэлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	0	2	0	100.0
Нийт дүн	2	0	2	0	100.0

Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг Орхон сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 09 сарын 02-ны 02/64 тоот албан бичгээр хариу өгсөн байна. Шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлж ажилласан байна.

### 3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 185,659,247.8 төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч аудитын явцад залруулга хийлээ.

Аудитаар залруулаагүй 3 зөрчил илэрч 3 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Цалингийн зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

##### 4.1.1 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 онд нэхэмжилсэн нэхэмжлэлийг шалгаж баталгаажуулахад нийт нэхэмжилсэн дүнгээс 112,533.1 мянган төгрөгийн, ЭМД-ын эмчийн хяналтаар 90,129.7 мянган төгрөг олгогдон 23,632.0 мянган төгрөг хасагдсан, хасагдлын шалтгааныг шалгах, зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, 16.1.14-т заасан нэхэмжлэлийн гүйцэтгэлд хяналт тавих, зөрчил илэрсэн тохиолдолд засч залруулах арга хэмжээ авах үүрэг, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын 2.6, 3.1.1, ЭМДЕГ-ын даргын 2025 оны А/30 тушаалаар баталсан “Нэхэмжлэлийг хянах журам”-ын 1.2-т заасан нэхэмжлэлийн хяналтын дүнгээр зөрчлийг арилгах, чанар сайжруулах, эргэх холбоо тогтоох шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна. заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

“Нэхэмжлэлийг хянах журам”-ын 1.2-т заасан нэхэмжлэлийн хяналтын дүнгээр зөрчлийг арилгах, чанар сайжруулах, эргэх холбоо тогтооход анхаарч ажиллах.

##### 4.1.2 Илрүүлэлт:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

ХХОАТ-ын даатгуулагчийн НДШ нь 1-р улирлаас 3-р улирлын хугацаанд цалин хөлсний тооцооны хүснэгтэд тайлагнасан даатгуулагчийн НДШ-ээс 1,347.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" буюу 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр" заалтуудтай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

ХХОАТ-ын тайланг гаргахдаа даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг тайлан болон цалингийн системийн мөнгөн дүнг тулган баталгаажуулж, үнэн зөв илэрхийлэн бүртгэл, тайланд тусгаж байх.

**4.1.3 Илрүүлэлт:**

1 дүгээр сараас 12 дугаар саруудын цалинг тооцоолохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн код алдаатай татагдснаас 2,323.9 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" буюу 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" 14.4.4. "аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр" 1заалтуудтай нийцэхгүй, аудитын үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Сар болгон тулгалт хийж нягтлан холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэлийг үнэн зөв хөтлөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлэхийг анхаарна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1 дүгээр сараас 12 дугаар саруудын цалинг тооцоолохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн код алдаатай татагдснаас 2,323.9 мянган төгрөгөөр буруу илэрхийлэгдсэн байна.	1	2,323.9					1	2,323.9				
ХХОАТ-ын даатгуулагчийн НДШ нь 1-р улирлаас 3-р улирлын хугацаанд цалин хөлсний тооцооны хүснэгтэд тайлагнасан даатгуулагчийн НДШ-ээс 1,347.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	1,347.2					1	1,347.2				
Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 онд нэхэмжилсэн нэхэмжлэлийг шалгаж баталгаажуулахад нийт нэхэмжилсэн дүнгээс 112,533.1 мянган	1	23,632					1	23,632				

**Булган аймгийн Орхон сумын Эрүүл мэндийн төвийн  
2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

төгрөгийн, ЭМД-ын эмчийн хяналтаар 90,129.7 мянган төгрөг олгогдон 23,632.0 мянган төгрөг хасагдсан, хасагдлын шалтгааныг шалгах, зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна													
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>27303.34</b>	<b>-</b>	<b>-</b>				<b>3</b>	<b>27303.34</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 104 мэдээллийг бүрэн оруулж, 3 мэдээлэл хоцорч мэдээлсэн 64 огт мэдээлээгүй байна.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, тендер зарлаагүй	1	0			1	0		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>			<b>1</b>	<b>0</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>0</b>			<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>